

Телевизийн халз мэтгэлцээнийн хөтлөгч

Л.Ариун, ХИС-ийн сэтгүүл зүйн тэнхимийн багш

Сонгуулийн үеэр ХМХ-үүд үзэл бодлын индэр, мэтгэлцээний талбар болж, нэр дэвшигч, улс төрийн намуудын байр суурийг ойлгуулж, сонгогчдод зөв сонголт хийхэд туслах ёстой билээ. Энэ үүргийг хамгийн сайн биелүүлэх нийтлэл нэвтрүүлгийн нэг нь телевизийн мэтгэлцээн бөгөөд ийм төрлийн нэвтрүүлэг өнгөрсөн УИХ-ын сонгуулийн үеэр маш олон теле сувагуудтай манай орны хувьд цөөхөн явж байсныг онцолмоор байна

Сонгуулийн үеэр явсан мэтгэлцээний нэвтрүүлэгийн хөтлөгчийн ур чадварыг дараах шалгуураар хэмжих авч үзлээ.

1. Хөтлөгч мэтгэлцээнт нэвтрүүлэгт оролцож буй хэн нэгэнд ая тал засахгүй, бүгдэд нь тэгш хандаж буй эсэх
2. Хөтлөгч мэтгэлцээнд оролцогчдод зохих шаардлагуудыг мөрдүүлж чадаж байгаа эсэх /тухайлбал — Оролцогч олгогдсон минутаа хэтрүүлэхгүй байх, хэтэрсэн тохиолдолд хариултыг таслах, Оролцогч асуултанд хариулахгүй өөр зүйл ярьсан тохиолдолд тасалж, асуултандаа хариулахыг шаардах, Оролцогч хэн нэгэн рүү дайрч давшлах, доромжлох гэх зэрэг зүй бус авир гаргасан тохиолдолд таслах зэрэг /
3. Мэтгэлцээнт нэвтрүүлгийн үеэр хөтлөгч оролцогчдод оновчтой, өөрөөр хэлбэл хөндвөл зохих, тухайн хүн хариулах боломжтой асуулт тавьж байгаа эсэх
4. Мэтгэлцээнт нэвтрүүлгийн үеэр хөтлөгч оролцогчдод тодорхой, өөрөөр хэлбэл нэг сонсоод ойлгогдохуйц, товч, сунжирсан биш, нэг асуултаар нэг л зүйлийг тодруулсан асуулт тавьж байгаа эсэх

1. **МҮТВ-ээр** явсан “Халз мэтгэлцээн” оролцогчдын хариулах дараалалыг суглуулах, дунд нь нэг л асуулт тавих, оногдсон 2 минутын хугацаанд хариулах зэрэг мэтгэлцээний стандарт шаардлагад нийцсэн дүрэм журамтайгаар явуулж байсан нь хөтлөгчийг тэнцвэр барих, шаардлага мөрдүүлэх зэрэгт ач холбогдолтой байлаа. Харин бусад телевизүүдийн хувьд /ТВ-9, Ийгл / дээрх дүрэм журам байхгүйгээс мэтгэлцээний хамгийн гол зүйл болох тэнцвэртэй байх зарчмыг ихээхэн зөрчиж байсан юм. Жишээлбэл ТВ-9 телевизийн “Мини парламент”-ийн хөтлөгч нь оролцогч болгонд харилцан адилгүй асуулт тавих мөн хариулах дараалал байхгүйгээс үзэмжээрээ хэн нь хариулахыг заах, оролцогчдоосоо их ярих, оролцогчын хариултыг илэрхий, шууд дэмжих зэргээр мэтгэлцээний хэм хэмжээг зөрчиж байсан. Тэр ч байтугай

нэвтрүүлгийн эхэнд МАХН-аас нэр дэвшиж буй төлөөлөгч хариулана. Яагаад гэвэл эрх баригч нам учраас эхэнд нь яриулах сонирхолтой байна гэсэн нь үнэхээр тэнцвэрт байдлыг алдагдуулсан юм. Ийгл телевизийн “Нээлттэй хэлэлцүүлэг” мөн л нэр дэвшигчдийн ярих дараалал байхгүй оролцогсдоос хэн дуртай нь яриад явчихдаг, хугацаа байхгүй, оролцогчид ярих зүйлээ дуустал нь хариулах хэлбэрээр явсан ба мэтгэлцээний дундуур улс төрийн реклам тэр дундаа нэг намын рекламыг дагнан явуулж байсан нь тэгш, шударга байх зарчмыг ихээхэн алдагдуулж байлаа.

Зарим оронд явуулдаг мэтгэлцээний дүрэмд дэвшигчидтэй ижил өнгө аясаар мэндлэх, харилцах тэр байтугай дууны өнгө, нүүрний хувирлаар оролцогсдыг дэмжсэн, эс дэмжсэн өнгө аяс гаргахгүй байх гэх мэтээр хөтлөгч ямар үйлдлийг яаж хийхийг нарийвчлан заасан байдаг байна. Гэтэл ТВ-5 телевизээр хийсэн МАХН, АН-ын дарга нарын мэтгэлцээний үеэр хөтлөгчид МАХН-ын дарга С.Баярт хандан асуухдаа “Баяр дарга та хариулана” гэсэн мөртлөө АН-ын дарга Ц.Элбэгдоржоос асуулт асуухдаа “Элбэгээ даргаас асуухад, Элбэгээ дарга хариулна” гэх мэтээр дотночилж дуудаж байсан нь мөн нь нэг талд нь ая тал засан тэгш байх зарчмыг зөрчиж байлаа.

2. Сонгуулийн үеэр явсан мэтгэлцээнд оролцогсод хөтлөгчийн асуултад хариулах бус бусад нам руу дайрах, нөгөөх нь хариу залруулга хийх, бусад мэдээллийн хэрэгсэл, сувгаар цацагдсан аливаа мэдээллийн няцаах зэргээр мэтгэлцээний шаардлагыг зөрчих явдал ихээхэн гарч байлаа. Ийгл ТВ, ТВ-9 телевизийн мэтгэлцээн цагийн хязгааралт байхгүй, сэдвийн хувьд ч чөлөөтэй байсан учраас дээрх телевизүүдийн мэтгэлцээний хөтлөгчид оролцогчдод шаардлага тавих, хариулыг таслан зогсоох тал дээр маш учир дутагдалтай ажилласан. Харин МҮОНТВ-ийн мэтгэлцээний хувьд Сонгуулийн хугацаа ойртох тусам, цуврал халз мэтгэлцээний сүүлийн дугааруудад оролцогсод ямар нэгэн залруулга хийх, бусад нам нэр дэвшигч рүү дайрч давшлах явдал ихэссэн. Тэр болгонд хөтлөгч таслан зогсоох, асуултандаа хариулах шаардлага тавьж чадахгүй байлаа. Жишээлбэл 6-р сарын 26-ны халз мэтгэлцээн-ээр БНН-ын дарга Б.Жаргалсайхан хөтлөгчийн асуултад хариулахгүйгээр “Баянхонгорт нэр дэвшиж байгаа манай намын тэр, Говь-алтайд дэвшиж байгаа намын нөхөр түүнд” гэхчилэн орон нутагт нэр дэвшиж байгаа намын төлөөлөгчидөө нэрлэн “амжилт хүсч байнаа” гэв. Оролцогсод ийнхүү мэтгэлцээний дүрмийг зөрчвөл шууд таслан зогсоох ёстой байдаг бөгөөд манай ТВ-үүдийн хөтлөгч, оролцогчдийн амыг харсан, аялдан дагах хандлага түлхүү байв. МҮОНТВ-ийн “Халз мэтгэлцээн”ийн сүүлийн нэвтрүүлэгт УИХ-ын сонгуульд нэр дэвшин өрсөлдөж буй 10 нам, 1 эвслийн дарга нар оролцсон ба өмнөх мэтгэлцээнүүдээс 30 минутаар урт хугацаатай явсан энэхүү мэтгэлцээний үеэр намын дарга нар асуултанд хариуцлахаасаа илүү хөтлөгчийг

шүүмжлэх, асуултыг эсэргүүцэх, хариулахаас татгалзах, оногдсон хугацаагаа чамлан 2 минутыг 3 болгон нэмэх зэргээр давуу эрх эдэлж байсан нь энэхүү мэтгэлцээний мэргэжлийн хэм хэмжээнд явуулах боломжийг хаасан юм. Тэр байтугай асуултгүйгээр өөрсдийн ярих гэсэн зүйлээ 3 минутын хугацаанд багтаан өгүүлэх шаардлага ч зарим оролцогч тавьж байлаа.

3. МҮОНТВ-ийн “Халз мэтгэлцээн”ий УИХ-ын сонгуульд нэр дэвшин өрсөлдөж буй 10 нам, 1 эвслийн дарга нар оролцсон сүүлийн нэвтрүүлэгт Хөтлөгчийн *“Намын удирдагчийн хувьд улс төрийн намын төлөвшил нь төрийн тогтоцлоонд хэрхэн нөлөөлж байна вэ?, Танай нам эвсэл засгийн эрхэнд гарвал засгийн газраа дангаараа болон хамтарч байгуулсан тохиолдолд хэнийг Ерөнхий сайдаар сонгох вэ “* гэсэн асуултанд зарим намын дарга нар хариулахас эрс татгалзаж, эрх баригч томоохон намуудад хамаарах асуулт байна хэмээн эсэргүүцсэн нь үндэслэлтэй юм. Тиймээс энэ асуултыг улс төрийн намуудын төлөвшлийн тухай болгон өөрчилсөн юм.

“Бидний **өнөөдрийн** сэдэв бол хуулийн хэрэгжилт байгаа. Өн **өөдрийн** монголд хууль хэрэгжихгүйгээр маш олон асуудал **үүсч** нийгмийн бухимдал бий болгоод байна. **Өнөөдөр** хуулийг илт зөрчсөн байхад түүнд хариуцлага хүлээлгэдэг хууль хяналтын байгууллага байхгүй байна. Т **өр** засаг алга. **Өнөөдөр** ийм байдалд хүргэсэн гол шалтгаан юу вэ?”, “Хуулийг хэрэгжүүлэхэд хэнээс эхлэх ёстой вэ? **Өнөөдөр** хүмүүс дээрээ нэгэнт зөрчилтэй байгаа юм чинь бид нар бол доод иргэд яаж мөрдөх вэ гэдэг?” гэх мэтийн оновчгүй асуулт цөөнгүй байлаа. Жишээ№ 01-т “Захын хороололын амьдралыг яаж сайжруулах вэ?” гэсэн асуултыг ийнхүү нуршиж, ойлгомжгүй, оновчгүй болгосон байна. Жишээ № 02-т УИХ д нэр дэвшиж буй оролцогчидоос та авилгалтай хэрхэн тэмцэх вэ гэж асуухаас төр авилгалыг яаж зохицуулах вэ хэмээн асуух нь маш оновчгүй юм. Түүнээс гадна эдгээр асуултад найруулга зүй, логикийн маш олон алдаа байна.

4. Мэтгэлцээний хөтлөгч сайтар боловсруулж бэлтгэсэн асуултыг оролцогсдод уншиж танилцуулах ёстой байтал найруулгын маш олон алдаатай, нуршуу, бүрхэг ойлгомжгүй асуулт олон байлаа. *Жишээ №03 юу асууж байгаа нь тодорхойгүй ийм асуулт тодорхой хариулт өгөхөд хүндрэл учруулдаг. №04 мөн нэг асуултыг ялимгүй хувиргаж хэдэнтээ асууж байна. Мөн тэдгээр асуултауд л сул үг ихтэй, найруулгын маш олон алдаатай байлаа.* Жишээ №05, 06, 07 зөвхөн нэг нэг нэвтрүүлгээс авсан асуултауд бөгөөд нуршуу ойлгомжгүй, тодорхойгүй, ач холбогдол багатай юм.

Эцэст нь теле мэтгэлцээний хөтлөгчид тавих хамгийн гол шалгуур бол намын харьяалалгүй, улс төрийн хувьд хараат байх өөрөөр хэлбэл улс төрд хутгалдаагүй улс

төрийн ажил эрхлэж байгаагүй хүн байх ёстой аж. Цаашлаад олонд зохих хэмжээгээр танигдсан, нэр хүндтэй хүн байх нь мэтгэлцээний үед улс төрчдөд шаардлага тавьж, яриаг таслан зогсоож чадна гэж үздэг байна. Зарим оронд теле мэтгэлцээний хөтлөгчид тусгайлан тавих шаардлагыг жагсааж, шалгаруулах явдал байдаг. Тэр ч байтугай хөтлөгч нь теле сэтгүүлч байх албагүй гэх тохиодолд бий. Олон улсын туршлагад мэтгэлцээнийг энэ хүн хөтөлнө гээд урьдчилан зарладаг ба мэтгэлцээний хөтлөгчийн үүрэг оролцоог тусгайлан заагаад өгчихдөг тохиолдол байдаг аж.

2008 оны сонгуулийн үеэр явсан телевизүүдийн мэтгэлцээнийг тухайн телевизийн туршлагатай сэтгүүлчид хөтлөн явуулсан. Энэ нь ололтой хийгээд дутагдагдалтай талтай байлаа. Дутагдагдалтай тал нь хөтлөгч тухайн сэдвийн хүрээнд тавьж буй асуултаа хэт нурших, санаагаа дутуу орхих, олон утга илэрхийлэх, оролцогчдын хариултыг онцлон илэрхий дэмжих, харин ололттой тал нь асуудлыг зөв чиглүүлэх сэдвээс хазайх, халих тохиолдолд анхааруулах зэргээр илэрч байв.

Манай теле сэтгүүл зүйн түүхэнд ингэж олон мэтгэлцээн зохион байгуулсан тохиодолд байхгүй бөгөөд оролцогчдод ч зохион байгуулагчдад ч, хөтлөгчдөд ч алдаа дутагдал байсныг тэмдэглэх хэрэгтэй. Гэвч телевизийн мэтгэлцээн манай теле сэтгүүл зүйд ихээхэн үгүйлэгдэж байгаа нэвтрүүлэгийн хэлбэр билээ.

2009 онд болох ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн байр суурийг олон нийтэд ойлгуулж, зөв сонголт хийхэд телевизийн мэтгэлцээний нэвтрүүлэг ихээхэн ач холбогдолтой нь ойлгомжтой. Ирэх ерөнхийлөгчийн сонгуулиар манай телевизүүд сайтар зохион байгуулсан мэтгэлцээнийг, өндөр ур чадвартай хөтлөгчтэйгээр явуулах нь сонгогч олон түмний өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, нэр дэвшигчдийн байр суурийг мэдээлэх зайлшгүй шаардлагаас урган гарч байгаа билээ. Тиймээс манай сэтгүүлчид телевизийн мэтгэлцээний загвар, хэлбэр, бүтэц, стандарт, зарчмын тухай мэдлэгээ дээшлүүлж, бусад орны теле мэтгэлцээн явуулж буй, арга зүй, туршлагаас суралцах шаардлагатай байгааг бидний судалгаа харууллаа.

“XIX зүйл ба эрх зүйн орчин” дугуй ширээний ярилцлага
2008.12.08